

“ТАЛЫН ГАЛ” ХК


213100 Баруун-Урт, Сүхбаатар аймаг, утас- /01512/ 22002

2026-02-19 № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД

Сүхбаатар аймгийн “Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн 2025 оны жилийн санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх тухай авч хэлэлцээд гаргасан шийдвэр, хурлын тэмдэглэл нийт 3 хуудас материалыг “Компанийн тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.14-т заасны дагуу гаргаж үүгээр хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

ТӨЛӨӨЛӨН ДАРГА  УДИРДАХ  ЗӨВЛӨЛИЙН
ХАТГААГАР  ХАТГААГАР



“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 2 дугаар
сарын 17-ний өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хурал 2026 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 10.00 цагаас Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо, Шаравын гудамж, 20-р байрны 301 тоот хурлын танхимд эхлэв.

Хуралд “Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга У.Батсуурь, гишүүн С.Янжмаа, С.Цэрэндондов, С.Зоригоо, Ш.Мягмарсүрэн, Б.Ялгуун, хараат бус гишүүн Ч.Түвшинбаяр, ерөнхий ня-бо М.Бямбажаргал нар оролцож, хурлыг ТУЗ-ийн дарга У.Батсуурь даргалав. Хуралд ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Дашпүрэв, Б.Болдбаатар нар оролцох боломжгүй байсан болно.

Хурлын тэмдэглэлийг тус компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал С.Цэрэндондов хөтлөв.

Хурлаар “Талын гал” ХК-ийн 2025 оны жилийн санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг авч хэлэлцэв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга У.Батсуурь Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс ногдол ашиг хуваарилах чиглэлээр албан тоотоор урьд өмнө ирүүлж байсан удирдамж, чиглэл болон Монголын хөрөнгийн биржийн вэбсайт 2026 оны 02 сарын 11-ний өдрөөс эхлэн шинэчлэгдэж байгаа талаар гишүүдэд танилцуулав.

Тус компанийн Санхүү, бүртгэлийн газрын захирал Ш.Мягмарсүрэн, Гүйцэтгэх захирал С.Цэрэндондов нар компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаар тодорхой танилцуулга хийв.

“Талын гал” ХК нь 2025 онд аймаг орон нутаг, хэрэглэгчдийн өмнө хүлээсэн зохих чанар, стандартыг хангасан нүүрсээр тасралтгүй ханган нийлүүлэх үүргээ сайн биелүүлсэн болно. Тус компанийн экспортын нүүрс борлуулах төлөвлөгөө хангалтгүй биелэж, алдагдалтай ажилласан талаар тусад нь танилцуулга хийх нь зүйтэй гэж үзэж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах боломжийн талаар тооцоо судалгаа гаргаж мэдээлэв.

“Талын гал” ХК-ийн Гүйцэтгэх захирал С.Цэрэндондов тус компани 2025 оны бизнес төлөвлөгөөгөөр 1206,0 мянган м3 хөрс хуулж, 600,0 мянган тн нүүрс нээж, дотоодод 85,0 мянган тн, экспортод 400,0 мянган тн нүүрс борлуулахаар төлөвлөснөөс 973,3 мянган м3 хөрс хуулж 80,7 хувь, 280,8 мянган тн нүүрс нээж, 43,7 хувь, дотоодод 94,5 мянган тн нүүрс борлуулж, 99,4 хувь, экспортод 44,8 мянган тн нүүрс борлуулж, 11,2 хувийн биелэлттэй байгааг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд тус компанийн 2025 оны жилийн ажлын болон санхүүгийн тайлангийн талаар асууж, тодотгосны үндсэн дээр компанийн хувьцаа эзэмшигчдэд нэг хувьцаанд 50,0 /тавин/ төгрөгийн ногдол ашиг хуваарилах нь зүйтэй гэж үзэж, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 1-нээр тасалбар болгохоор, Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 49 дүгээр тогтоолыг үндэслэн ногдол ашгийг энэ оны 4 дүгээр сарын 30-ны дотор ҮЦТХТ ХХК-иар дамжуулан тараах шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзэв.

Хурал асуудлаа хэлэлцэж дууссан тул 12.30 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ийн гишүүн

ТАНИЛЦСАН:

ТУЗ-ийн дарга

Хараат бус гишүүн

С.Цэрэндондов

У.Батсуурь

Ч.Түвшинбаяр



“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 19-ний өдөр

№01

Улаанбаатар хот

“Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай авч хэлэлцээд ТОГТООХ нь:

1. “Талын гал” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг авч хэлэлцээд тус компанийн хувьцаа эзэмшигчдэд нэг хувьцаанд 50.0 /тавин/ төгрөгийн ногдол ашиг хуваарилах нь зүйтэй гэж үзсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгохоор, Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 49 дүгээр тогтоолыг үндэслэн ногдол ашгийг энэ оны 4 дүгээр сарын 30-ны дотор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв /ҮЦТХТ/ ХХК-иар дамжуулан тараахаар тус тус тогтоосугай.

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



У.БАТСУУРЬ